

Доктор (Ph.D) Ж.Бор
МУИС-ийн ОУХС-ийн багш
Р.Давааням
МУИС-ийн ОУХС-ийн магистрант

Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого ба Монгол улсын эрх зүйн актууд

Түүхийг эргэн санахад тухайн цаг үедээ тэргүүлэгч байсан улс орон өөрийнхөө нөлөө, байр сууриа тэлэх, хадгалах, аюулгүй байдлаа хангахын тулд бусад орнуудад улс төр, эдийн засгийн дарамт шахалт үзүүлэх, цэрэг зэвсгийн хүчээр түрээ барих зэргээр хусэл сонирхлоо тулган хүлээлгэхийг урьтал болгох хандлага слонтаа гарч байсан билээ. Түүнд бага буурай орнууд ихэд өртдөг байжээ.¹ Харин өнөө үед улс орнууд дэлхий дахин аюулгүй оршихтой холбогдсон асуудлаа цогцолбороор шийдэх үзэл санаа бий болж үүнийг нийтээр Comprehensive security хэмээн нэрлэх боллоо. Энэхүү үзэл санаа бий болох угтвар нөхцөл нь дэлхийн улс орнууд бие биенээсээ үлэмж хамааралтай болж нэг улсын аюулгүй байдал нөгөө улсынхаар нөхцөлдөх болсонтой холбоотой юм. Өнөөдөр олон улсын харилцаанд улс орнууд хүчний тэнцвэрт тулгуурлан, хамтын хүчин чармайлтаар үндэсний аюулгүй байдлаа хамгаалахаас өөр аргагүй болоод байна. Өөрөөр хэлбэл Comprehensive security гэдэг нь нэг дайсны (тэр дайсан нь илэрч гарч ирээгүй, эсвэл нуугдмал байдалтай байлаа ч) эсрэг чиглэсэн шинжтэй эвсэл бүлэглэл байгуулан өөрсдийн аюулгүй байдлыг хамтын хүчээр хамгаалах (үүний нэг илрэл нь терроризмтэй хийж буй тэмцэл, Ирак дахь үйл ажиллагаа) гэдэг үзэл санаа юм. Улс орнууд, бүс нутгийн дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлыг нягт шүтэлцээ, холбоонд нь авч үзсэн "Comprehensive security"-ийн ойлголтыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч үндэсний аюулгүй байдалдаа үндсэн баримжаа² болгож байна.

Харин тухайн нэг улсын аюулгүй байдлын асуудал нь гадаад, дотоод олон хүчин зүйлээс шалтгаалж байдаг бөгөөд хэрхэн яаж хадгалаж, хамгаалах вэ? гэдэгт түүний олон улсын тавцан дээр эзэлж буй байр суурь, нөлөө (олон улсын нэр хүнд, эдийн засаг улс төр, цэрэг зэвсгийн нөөц) зэрэг нь ихээхэн чухал гэдэг нь ойлгомжтой. Тэр дундаа дэлхий нийтээр даяарших чиг хандлагатай болсон өнөө үед бүр тодруулбал эдийн засаг, улс төрийн нөлөө, олон улсын тавцан дээрхи нэр хүнд бага жижиг орны (жижиг улсууд гэж гадны нөлөөнд автагдахдаа амархан, үйлдвэрлэлийн томоохон салбаруудыг хөгжүүлэх эдийн засгийн үндэслэл бүрдээгүй, дутмаг, иж бүрэн эдийн засгийн цогцолбор байгуулах боломж муу, үндэсний шинжлэх ухаан оюуны чадавхи, бие даан хөгжих чадвартай технологийн бааз үүсгэх бололцоо хязгаарлагдмал, гадаад худалдаанаас өндөр хамааралтай, их гүрнүүдийн хувьд багаханд тооцогдох бэрхшээл тэдний хувьд томоохон бэрхшээлд тооцогдох зэрэг нийтлэг шинжүүдтэй байдаг)³ хувьд үндэснийхээ аюулгүй байдлыг хэрхэн яаж хангаж, хамгаалах, цаашид хэрхэн авч үлдэх вэ? гэдэг асуудал нь их гүрнүүд, хөгжингүй улсуудтай харьцуулбал их хурцаар тавигдаж байгаа асуудлын нэг болоод байна. Өөрөөр хэлбэл их гүрнүүд, хөгжингүй улс орнуудын хувьд өөрийн ашиг сонирхлын хил хязгаарыг хэрхэн тэлэх, түүнийг бусад орнуудад хэрхэн хүлээн зөвшөөрүүлэх вэ? гэдэг асуудал анхаарлын төвд оршин байдаг бол жижиг улс орнуудын хувьд өөрийн оршин байгаа хил хязгаарыг хэвээр хадгалах, бусдаар хүлээн зөвшөөрүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулах, өөрийн ашиг

¹ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс. УБ.1999. 5 дахь тал

² Олон улс судлал сэтгүүл. УБ.2001. №1.1 дэх тал

³ Монгол улсын аюулгүй байдал ба гуравдагч түнш орнууд. УБ.2003. 44 дэх тал

сонирхлоо их гүрний ашиг сонирхолтой хэрхэн ашигтай байдлаар уялдуулж холбох зэрэг асуудал нь аюулгүй байдлын цөмд оршиж байдаг,

Улс орнууд аюулгүй байдлаа дараахь арга зам хүчин зүйлд тулгуурлан хангаж байдаг, Үүнд:

-өөрийнхөө онцлог, нөөц боломж, чадвар, чадавхид тулгуурлах,

-олон улсын эрх зүй, олон улсын байгууллагад тулгуурлах,

-аль алиныг нь хослуулан хэрэглэх аргаар хангаж байна. Дэлхий нийтийг хамарсан даяарших үйл явцтай уялдан нийтээр өөрийн гадаад харилцаа, гадаад бодлогодоо олон улсын түгээмэл эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг анхаарах, цаашлаад үндэсний хууль, эрх зүйн орчин, гадаад бодлогынхоо зарчмуудад тусгахыг шаардаж байна. Гэхдээ энэ нь олон улсын эрх зүйн заалт болгоныг өөрийн хууль болгон мөрдөх гэсэн үг биш тухайн орон өөрийн онцлог, нөөц боломж зэргээ харгалзан үзэх ёстой нь ойлгомжтой,

Өөрөөр хэлбэл улс орнууд жин нөлөө зэргээсээ шалтгаалан өөрийн аюулгүй байдлаа хангахад дараахь ялгаатай арга зам, хэрэгслүүдийг ашигладаг, Үүнд:

-Эдийн засгийн нөөц, хөгжингүй эдийн засаг,

-Цаг үеэ мэдэрсэн, нийцсэн, ухаалга уян хатан гадаад бодлого,

-Цэрэг зэвсэг, батлан хамгаалах зохих чадвар зэрэг юм. Харин жин нөлөө, нэр хүнд багатай жижиг улс орон тэр дундаа манай улсын хувьд үүнээс цэрэг, зэвсгийн хүчээр өөрийн аюулгүй байдлаа хамгаалах чадавхи, нөөцгүй, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил сул учир дээрхи арга хэрэгслүүдээс зөвхөн идэвхитэй, уян хатан гадаад бодлого, олон улсын эрх зүйд дулдуйдан аюулгүй байдлаа хангах арга зам л үлдэж байна, Гадаад бодлого нь үндэсний язгуур эрх ашгаас улбаатай, түүний логик үргэлжлэл бөгөөд язгуур эрх ашгийн тухай ойлголт нь тухайн орны түүхэн хөгжил, газар зүйн байршил, стратегийн нөхцөл байдал, эдийн засгийн хүчин чадал, эрхэмлэдэг үнэт зүйлсээр тодорхойлогддог¹. Харин манай орны хувьд гадаад бодлогын ач холбогдол, жин нөлөөг өргөж байгаа бас нэг гол хүчин зүйл нь газарзүйн байршил юм. Өөрөөр хэлбэл цэрэг зэвсгийн хувьд хүчирхэг, цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, дэлхийн болоод бүс нутгийн зам, тээврийн сүлжээнд нэгдэж чадаагүй, гадаад ертөнцтэй харилцахад хоёр гүрнээс тодорхой хэмжээгээр хамааралтай хэвээр байгаа зэрэг онцлог байдал юм. Эдгээр улсуудын ашиг сонирхол Монгол улсаар ямар нэг байдлаар тодорхойлогддог өвөрмөгц онцлог байдал нь үндэсний аюулгүй байдлаа хангахад гадаад бодлогын үүрэг ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

Олон улсын харилцаанд эзлэх жин нөлөө, газарзүйн байршил зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан ухаалаг уян хатан бодлого баримтлах зайлшгүй шаардлагатай манай орны хувьд гадаад улс орнууд, олон улсын харилцааны асуудлууд, цаг үеийн үйл явцыг судлах ажил нэг үеэ бодвол идэвхитэй хийгдэж байгаа ч энэхүү үйл явц нь манай оронд хэрхэн нөлөөлөх, түүнд манай улсын зүгээс баримтлаж байгаа байр суурь нь эрх зүйн акт, баримт бичгүүдэд хэрхэн туссан байдаг, түүнийг баримтлах асуудал ямар түвшинд байна, тэрхүү зүйл заалтууд нь өөрөө эргээд цаг үеийн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар төдийлөн судалгаа хийгдэхгүй байна уу гэж бодогдож байна,

Гадаад бодлогыг олон улсын эрх зүйн талаас нь "Гадаад бодлого гэж олон улсын харилцаанд улс орнуудын баримтлах ерөнхий чигийг гадаад бодлого гэнэ", "гадаад бодлого нь тухайн улсаас бусад улс, ард түмэнтэй харилцах ажиллагааны удирдамж юм"⁶⁴ гэж тодорхойлдог.

Манай оронд 1990-ээд оноос өрнөж буй ардчилсан өөрчлөлт нь 70 гаруй жил оршин тогтнож байсан гадаад орчин, гадаад харилцааны уламжлалыг үндсээр нь өөрчилсөн. Энэхүү нөхцөл байдлыг Монгол улсын анхны

¹ Д.Баярхүү. Евроазийн геополитик, олон улсын харилцаа 7 дахь тал

ерөнхийлөгч Очирбатын гуайн хэлснээр "Төрөө төвхнүүлэхээс Монгол Улсын гадаад бодлогынхоо зарчмуудыг зарлаж, алхмуудаа хийж эхэлсэн, Улс орнуудын гадаад бодлогын хөзөр улам ил тод болж ардчилагдаж буй нь анзаарагдах болжээ, Ардчиллаас өмнө Монгол орон хоёрхон цонхтой байсан гэхэд хэлсдэхгүй хоёр хөршөөсөө цааш харахаас эмээдэг байлаа, Одоо бол дөрвөн зүйг найман зовхист цонхоо дэлгэлээ, 1990 оноос хойш Монгол Улсын гадаад бодлогын онол, зорилго, баримтладаг зарчим, үр дүнгийн шалгуур бүгд өөрчлөгдсөн. Гадаад бодлогод үндэсний эрх ашиг гэдэг гол зарчим үйлчилж олон тулгуурт харилцаанд түшиглэж байна" гэсэн байдаг.¹ Өөрөөр хэлбэл өөрийн орны гадаад аюулгүй оршин байх баталгааг хуучнаар ЗХУ болгож байсан уламжлалт байдал үгүй болсноос өөрөө өөрийнхөө аюулгүй байдлын баталгааг хангах шаардлага гарсан, 1990-ээд оноос өмнөх Монголын гадаад бодлогын ерөнхий зарчим нь "социалист маягийн шинэ харилцаа" гэсэн үзэл санаанд тулгуурлаж байсан бол өнөөдөр олон улсын эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл онолд тулгуурлах боллоо.² Энэхүү шинэ нөхцөл байдал, өөрийн орны онцлог байдлыг харгалзан гадаад бодлогодоо баримтлах гол зарчмуудыг бодитой, үнэн зөв тодорхойлох, холбогдох хуулиудад тусгах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох ажлыг нэн даруй хийж байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улс олон түнш, найз нөхөдтэй боллоо. Дэлхийн нийтийн үйл явцад онцгой байр суурь эзэлдэг Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын бүрэн эрхт гишүүнээр элслээ. Олон улсын аюулгүй байдал, хүний эрх, гэмт хэргийн эсрэг тэмцэл, олон улсын худалдаа, тээвэр холбоо, оюуны өмч, далайн эрх, хүрээлэн буй орчин зэрэг салбарын олон талт 75 гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, олон улсын эрх зүйн хамгааллыг аль болох бүрэн дүүрэн эдлэх боломж бүрдэж байна.

Энэхүү шинэ нөхцөл байдлыг харгалзсан өөрчлөлтүүд нь Монгол Улсын эрх зүйн үндэс шинэ Үндсэн хуулинд тусгалаа олсон бөгөөд Монгол Улсын Их Хурлаас 1994 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад холбогдох хуулиудыг батлан гаргасан нь Монгол төрийн орчин цагийн гадаад бодлогын чиг шугам, үйл ажиллагааны үндсийг тодорхойлоход онцгой түлхэц үзүүлснийг тэмдэглэх нь зүйтэй.

Өнөөдөр улс орнуудын харилцаа улам бүр ойртон нягтарч байгаа үед өөрийн орны улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн болон бусад ашиг сонирхлоо хадгалах, хөгжүүлэх нь бидний зүгээс гадаад орчин, дэлхий дахинд болж байгаа үйл явцыг хэр зөв мэдэрч ухаалаг, уяан хатан гадаад бодлого явуулахаас шууд хамаарна. Гэхдээ дэлхий нийтийн буюу бүс нутгийн чанартай ямар ч асуудлыг нэг улс битгий хэл хэсэг улс ч дангаар шийдэхэд хүчин мөхөсдөх, харилцан бие биеэсээ хамаарах хамаарал улам бүр нэмэгдсэн шинэ орчин нөхцөл бий болоод байна. Өөрөөр хэлбэл орчин үед аливаа үйл явц харилцан уялдаатай, нэг нэгнээсээ хамааралтай болсон учраас аль нэг орон аливаа асуудлыг бусдаас салангид байдлаар шийдвэрлэх боломжгүй болжээ. Чухамхүү эдгээр нөхцөл байдлыг Монголын төр засаг тооцож уян хатан гадаад бодлогоо явуулах учиртай.

Өнөөдөр олон улсын харилцаанд баримтлах Олон улсын эрх зүйн 10 зарчим /бүрэн эрхийн зарчим, тэгш эрхийн зарчим, газар нутаг бүрэн бүтэн, хил дархан халдашгүй байх зарчим, дотоод хэрэгт үл оролцох зарчим, олон улсын маргааныг эв зүйгээр шийдвэрлэх зарчим, хүч үл хэрэглэх, хүчээр үл заналхийлэх зарчим, улс үндэстнүүд өөртөө засан тохинох зарчим, хүний эрхийг нийтээр хүндэтгэх зарчим, хамтын ажиллагааны зарчим, олон улсын үүргээ

¹ Д.Баярхүү. Ервоазийн геополитик, олон улсын харилцаа одоо ба ирээдүй 3 дах тал

² М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс. УБ.1999 5 дахь тал

шударгаар биелүүлэх зарчим¹ нь Монгол улсаас Үндсэн хуулиндаа Олон Улсын эрх зүйн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмуудыг баримтлан энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна² гэсэн заасан заалтаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг бөгөөд олон улсын эрх зүйн зарчмууд нь манай улсын хууль, баримт бичгүүдэд дараахь хэлбэрээр туссан байдаг. Үүнд:

Монгол улс нь гадаад бодлогодоо “нээлттэй байх”, “үндэсний язгуур ашиг сонирхол, үндэсний ашиг сонирхолоо дээдлэх, олон түнштэй байх”, “эвсэлд үл нэгдэх”, “хоёр хөрш оронтойгоо харилцах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч тэнцвэртэй харилцах”, “төвийг сахих”, “гадаадын цэрэг, зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэр дээрээ үл байрлуулна” гэж заагдсан байдаг.

Монгол Улсын гадаад аюулгүй байдлын эрх зүйн асуудлыг тодруулахдаа Монгол улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Гадаад бодлогын үзэл баримтлал баримт бичгүүдийг судлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл дээрх баримт бичгүүд нь Монгол улсаас гадаад орнуудад явуулах бодлогын гол гол үзэл санаа, зарчмууд тусгагдсан байдаг. Тухайлбал:

Монгол Улс өөрийн орны онцлог байдлаас шалтгаалан үндэснийхээ аюулгүй байдлыг хангах асуудал дээр гадаад бодлогодоо онцгой ач холбогдол өгдөг. Үзэл санаа үндсэн хуулийн аравдугаар зүйлд “Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлаж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна”³ гэж заасан байдлаас харагдаж байна.

Мөн тус хуулинд гадаад бодлоготой холбогдох асуудлуудыг тусгахдаа гадаад бодлогыг явуулах субъектууд тэдгээрийн эрх, үүргийн хувиарлалтыг тодорхойлж өгсөн байна.

Өнөөдөр олон улсын хэмжээнд тухайн улсын тусгаар тогнолыг хангах нэг гол арга хэрэглүүр нь төрийн бодлого түүний гол илэрхийлэл болсон хууль тогтоомж улсынхаа нутаг дэвсгэрт төгс төгөлдөр үйлчилж байх явдал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Харин Монгол улс Үндсэн хуулиндаа тус хуультай харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй⁴ гэж заасан байна. Энэ нь зарчмын шинэ заалт юм. Гэхдээ “харшилсан” бус нийцсэн бол Монгол Улс олон улсын гэрээгээр үүргээ шударгаар биелүүлнэ⁵ гэсэн санаа бас үүний цаана байна гэж ойлгож болох ч харин олон улсын эрх зүйд зааснаар Олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь улс гүрний дотоод хууль зүйгээс давамгайлах хүчинтэй гэж заасан байдаг ба энэ нь Олон Улсын гэрээний Эрхийн тухай Венийн 1969 оны Конвенцид тод илрэлээ олсон байдаг. Конвенцийн 27 дугаар зүйлд зааснаар гэрээнд оролцогч улс орон “гэрээний үүргээ биелүүлээгүй явдлаа дотоодын хууль зүйн заалтаар зөвтгөж үл болно” гэж заасан байдаг. Энэхүү зарчим ёсоор улс орны дотоодын хууль зүй нь Олон Улсын Эрх Зүйтэй нийцсэн байх ёстой. Эдгээр нь хоорондоо зөрчилдвөл Олон Улсын Эрх зүйг баримтлана⁶ гэж заасан байдаг. Харин дээрхи байдлаас тус хуулин дахь заалтаас үзвэл үзвэл тус заалт нь олон улсын эрх зүйн үүрийг бууруулсан шинжтэй заалт байх болох талтай. Хэдийгээр энэ заалтыг нь “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд харшилсан олон улсын гэрээ бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэж тайлбарлаж болох ч олон улсын гэрээ өөрөө аливаа улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдлыг дээдлэх зарчим дээр үндэслэгдсэн байдаг. Орчин үед олон улсын эрх зүй нь

¹ Олон улс судлал сэтгүүл 2002 №1 .,111 тал

² Монгол Улсын аюулгүй байдал ба гуравдагч түнш орнууд. УБ.2003 44 дэхь тал

³ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон Улсын эрх зүй УБ. 1999 8 дахь тал

⁴ Дорно-Өрнө” сэтгүүл. 1994 №2 Ц.Гомбосүрэн Монгол улсын гадаад бодлог 90-ээд онд

⁵ Мөн тэнд 15-23 дахь тал

⁶ Үндсэн хууль 1-р бүлэг 10-р зүйл 1

тухайн улсын аюулгүй байдлаа хамгаалах нэг гол үндэс нь болоод байгааг бодолцвол Монгол Улсын Үндсэн хуулийн дээрхи заалт оновчтой эсэхэд эргэлзэх сэтгэл төрүүлж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын асуудлыг авч үзэх гол тулгуур баримт бичиг бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал юм.

Тус үзэл баримтлал нь шинээр бий болсон нөхцөл байдлаас үүдэн төрөөс "аюул" гэдгийг нэг бол "гадаадын түрэмгийлэл", эсвэл "үзэл сурталын дайсагнал", "дотоодын эсэргүү" гэсэн утга агуулгаар явцуу хүрээнд төсөөлж байсан нийгмийн ойлголт хуучирсантай холбоотойгоор шинээр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа тодорхойлох шаардлагатай болсон байдалд боловсруулан баталсан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь 11 хэсэг, 56 зүйлээс бүрдсэн, нилээд нягт боловсруулсан, дэлгэрэнгүй баримт бичиг болж чадсан. Энэхүү баримт бичгэнд "Үндэсний аюулгүй байдал", "Үндэсний язгуур ашиг сонирхол", үндэсний аюулгүй байдлын бүтэц, улс орны аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлийн ангилал зэрэг чухал ойлголтуудын албан ёсны тодорхойлолт, томъёоллыг түүнд анх удаа гаргаж, үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгааг зааж өгсөн нь уг баримт бичгийн шинэлэг, давуу талууд болж чадсан.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын тулгуур ашиг сонирхлыг хангах, гадаад дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ"¹ гэж тодорхойлсон. Үүнээс Монгол Улсын Үндэсний аюулгүй байлыг орон зайн хувьд одоогийн баталгаажсан хил хязгаарын хүрээнд, нөгөө талаас аюулгүй байдлаа нэгэнтээ хангагдсаныг бус, харин түүнийг хангах таатай нөхцлүүд хэр зэрэг баталгаатай бүрдсэн болохыг тодруулсан хэмжүүр болох нь харагдаж байна.

Тус үзэл баримтлалд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц хүчин зүйлсийг чанарын үүднээс нь объектив, субъектив байдлаар учруулах нөлөөгөөр нь бодит болон болзошгүй гэж ангилсан². Улс төрийн орон зайн хувьд аюулгүй байдлыг дэлхийн, бүс нутгийн, салбар бүс нутгийн гэж тус тус ангилсан байна.

Үзэл баримтлалын дагуу Монгол улсыг дэлхийн хамтын нийгэмлэгийн эрх тэгш, бие даасан, хөгжиж буй, ардчилсан улс болгон хөгжүүлэх, бүс нутагт интеграцчилах, дэлхийн улс төрийн бодлого, бүс нутаг, салбар бүс нутгийн түвшинд тухайлбал Аливаа цэргийн эвсэлд хамрагдаж аюулгүй байдлаа хангах бус харин хамтын аюулгүй байдлын тогтолцоог бий болгох хэрэгт үр бүтээлтэй хувь нэмэр оруулдаг олон улсын харилцааны субъект болгох зорилт бүхий Монгол Улсын "Нээлттэй" гадаад бодлого нь үндэсний аюулгүй байдлыг хангах улс төрийн гол арга хэрэгсэл болж өгөх ёстой аж.

Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам баталгааны хувьд нь нийгмийн, улс төр, зохион байгуулалт, эдийн засаг, дипломат, цэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангана гэж заасан. Дээрхи аюулгүй байдлыг хангах арга замуудаас манай улс шиг газар нутаг өргөн уудам, баялаг ихтэй, хүн ам цөөнтэй, хоёр их хөрштэй улсад хамгийн чухал арга зам нь дипломат яриа хэлэлцээ тэр дундаа олон улсын хамтын үйл ажиллагааг хөгжүүлэх замаар хангахаар заасан нь гадаад бодлогын ач холбогдлыг бодиттой үнэлсэн нэг алхам болсон.

Үзэл баримтлалд Монгол Улсын өөрийн оршин тогтнохын аюулгүй байдлын асуудлыг хамгийн тэргүүнд хөндөн тавьсан нь ихээхэн сургамжтай бөгөөд олон улсын тавцанд болон үндэсний аюулгүй байдлын бүх нарийн

¹ Монгол улсын үндсэн хуулийн 10-р зүйлийн 4

² Үндсэн хуулийн үзэл баримтлал 25 дахь тал

төвөгтэй цогцыг хангах салбарт явуулах төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлжээ¹.

Дээрхи асуудлыг шийдвэрлэх, Монгол Улсад ямар нэгэн байдлаар занал учруулж болох янз бүрийн нөхцөл байдлаас зайлсхийх, түүнийг арилгахад улс төрийн хэрэгсэл, урьдчилан сэргийлэх аргыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын голд тавьсан байна. Чухам эндээс эвсэлд үл нэгдэх, өөрийнхөө нутаг дэвсгэрийг бусад орны эсрэг ашиглуулахгүй байх, Орос-Хятадын харилцааны өрнөлтөд хөндлөнгөөс оролцохгүй байх, тэдгээр улсуудад ямарваа нэг хурцадмал асуудал гарсан үед энэ нь Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд харшлаагүй тохиолдолд тухайн асуудалд төвийг сахих байр сууринаас хандах гэдгээс энэхүү үзэл баримтлалын амин чухал зарчмууд урган гарчээ.²

Монголын үндэсний эрх ашгийн үүднээс ч гэсэн цөмийн зэвсэг бүхий хоёр гүрний харилцааны төлөвшил чухал юм. Тэглээ ч дангаараа энэ хүчин зүйл Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын баттай баталгаа болж чадахгүй. Хэдийгээр Орос, Хятадын хооронд өнөө үед илт сөргөлдөөн байхгүй байгаа ба нөгөөтэйгүүр аль аль нь дотоодынхоо улс төр, эдийн засагын асуудалд ихээхэн анхаарал хандуулж байгаагаас шалтгаалж ойрын хэтдээ өөрсдийн байр суурийг Монголд идэвхжүүлэх сонирхол төдийлөн байхгүй байгааг анхааран үзэл баримтлалдаа тусгасан байна.

Мөн нөгөөтэйгүүр тус үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлын үндсэн баталгаа нь Монголын ард түмэн өөрөө, Монгол Улсын төр мөн³ ба олон улсын баталгаа нь улс төр, хууль зүй, ёс суртахуун-сэтгэлзүйн баталгаанаас бүрдэнэ. Олон улсын баталгааг дангаар, хоёр бопон олон талын арга хэмжээг хослуулах замаар буй болгож бэхжүүлнэ. Цэрэг улс төрийн аюулгүй байдлын баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоог хангах бүрдүүлэх, оролцох замаар хангана.⁴ гэж заасан. Өнөөдрийн байдлаар Монгол Улс батлах хамгаалах салбарт идэвхитэй хамтын үйл ажиллагааг өрнүүлж байгаа ба батлах хамгаалахын хамтарсан удаа дараагийн үйл ажилагааг явуулсан, Одоогоор нийт 141 улстай дипломат харилцаа тогтоож дэлхийн болон бүс нутгийн шинжтэй алив асуудалд идэвхитэй байр суурь баримтлаж байна. Эндээс үзвэл Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангахад олон улсын хууль эрх зүй чухал бөгөөд энэхүү баталгааг хэрэгжүүлэхэд хоёр их хөрштэй харилцах харилцаа болон гуравдагч орнуудтай харилцах, олон улсын тавцанд идэвхитэй үйл ажиллагаа явуулах замаар өөрийн байр суурь нэр хүндийг өргөх нь чухал болох нь харагдаж байна.

Тус үзэл баримтлалд заасан нөгөө нэг гол санаа бол "Монгол Улс нээлттэй" гадаад бодлого явуулж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар нөлөө бүхий улсуудтай зөвлөлдөж, улс орныхоо стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлж нөлөө бүхий улс орнуудын ашиг сонирхлыг Монголд бий болгох бодлого явуулна гэсэн санаа юм. Дээрх байдлаар асуудлыг ойлговол Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "үндэсний язгуур ашиг сонирхолд аюул занал учраагүй нөхцөлд Монгол улс эвсэлд үл нэгдэх гадаад бодлого явуулна"⁵ гэж заасан байдаг. Харин өнөөдөр улам бүр даяаршиж байгаа дэлхий ертөнц, олон улсын харилцаанд Монгол улс гадаад харилцаандаа олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, өөрийн орны эдийн засаг, улс төрийн

¹Найдансүрэн, Т.Содномгомбо. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал түүнийг хангах зарим асуудал. УБ.2000 42 дахь тал

²Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 5 дахь тал

³Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 7-р зүйл

⁴Мөн тэнд 10-р зүйл

⁵Дорно Өрнө сэтгүүл. 1995 №1-2

харилцаагаа хөгжүүлэх зорилготой аливаа эвсэл, холбоонд нэгдэхгүйгээр оршин боломж хэр байна вэ? гэдгийн тодруулах нь зүйтэй болжээ.

Олон улсын харилцаанд тухайн улс гадаад харилцаандаа баримтлах ерөнхий чиг шугамыг гадаад бодлого гэнэ¹ гэсэн ерөнхий ойлголт байдаг.

Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах нэг чухал арга хэрэгсэл нь гадаад бодлого, идэвхитэй дипломат үйл ажиллагаа юм. Ийм ч учраас Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг боловсруулан төрийн эрх бүхий байгууллагуудын хүрээнд дагаж мөрдөж байна. Энэхүү үзэл баримтлалд Монгол улсын гадаад бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Монгол улсын авч хэрэгжүүлэх улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи болон соёл хүмүүнлэгийн чиглэлд баримтлах гадаад харилцааны бодлогын чиглэлийг тодорхойлж өгчээ.

Монгол улсын гадаад бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд Монгол улсын гадаад, дотоод өвөрмөц байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

Монгол улсын гадаад бодлого нь тус улсын Үндсэн хуульд тодорхойлон заасан үндэсний ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд Монгол улсын гадаад, дотоод өвөрмөц байдал нь гадаад бодлогын зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

Олон улсын эрх зүйд Төвийг байнга сахисан статусыг заахдаа: "Дайны үед дайтагч аль нэг улсыг дэмжин оролцохгүй, цэргийн тусламж үзүүлэхгүй байх үүрэг авсан улсыг төвийг байнга сахисан улс гэнэ. Бусад улс төвийг байнга сахисан улсын статусыг хүндлэх үүрэгтэй. Тайван үед төвийг байнга сахисан улс цэргийн эвсэл, холбоонд оролцохгүй байх ёстой"² гэж заасан байдаг бол Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх бодлого явуулна мөн цэргийн аливаа эвсэл бүлэглэлд үл нэгдэх, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэрэг зэвсэг, түүний дотор цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтлана гэж заасан байдаг дээрх зүйл заалтуудаас үзэхэд Монгол Улс олон улсын гэрээгээр төвийг байнга сахисан улсын статустай болох боломжтой байгааг илрэл юм.

Гэхдээ Монгол улсын төвийг сахих дээрхи үзэл баримтлал нь хоёр хөрш улсад гарсан аливаа зөрчил тэмцэлд оролцохгүй төвийг сахисан байр суурь баримтлана гэж шууд утгаар нь ойлгож болно. Гэхдээ Монголын тал зөвхөн хоёр хөршийн маргаанд төвийг сахихаас бус олон улсын аюулгүй байдлын асуудлаар төвийг сахина гэж ойлгож болохгүй юм. Энэ нь жижиг орны аюулгүй байдал ашиг сонирхолд нийцсэн хязгаарлагдмал төвийг сахих бодлого юм.

Монгол Улсын хоёр хөршийн сөргөлдөөнд төвийг сахих байр суурь нь тэдгээрийг сөргөлдөхгүй үед нь тэдний "аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй" харилцах бодлогын үргэлжлэл юм.

Тус үзэл баримтлалд өндөр хөгжилтэй улсуудын бодит сонирхолыг Монголд бий болгох бодлого баримтлахын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ. Гадаад орнууд дахь Монголын сонирхолыг улс төр-эрх зүйн аргаар бататган хамгаална³ гэж зааснаараа дан ганц төвийг сахисан байдлаар улсынхаа аюулгүй байдлыг хангах бус бас олон улсын тавцанд гадаад идэвхитэй бодлого явуулж эрх зүйд дулдуйдах замаар аюулгүй байдлаа хангана гэснээрээ хамгийн чухал шинэлэг зүйл болж чадсан байна.

¹ Мөн тэнд . 1995 №1-2

² Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 12-р зүйл

³ Мөн тэнд 13-р зүйл

Үзэл баримтлалд Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх гадаад бодлого явуулна гэж заасан. Нээлттэй бодлого гэдэг нь манай улс гадаадын бүх оронтой харилцан ашигтай эдийн засаг, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж хөгжингүй орнуудын бодит сонирхолыг эх орондоо бий болгоно¹ гэсэн үг.

Өөрөөр хэлбэл бид улс төр, мэдээлэл, шинжлэх ухаан, технологи, хүмүүнлэгийн хувьд гэхчлэн бүхий л салбарт нээлттэй байхыг хамруулж ойлгож байна. Гэхдээ аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ. /Эдийн засгийн, цагаачлалын, шашины гэх мэт/ Өөрөөр хэлбэл нээлттэй бодлого гэдэг маань тус улсын үндэсний ашиг сонирхолд хохирол учруулахгүй, харшлахгүй тэр л хэмжээндл байх ёстой. Үндэсний эрх ашигт хохирол учруулахгүй бол бид аль ч улстай үл сөргөлдөх, үл дайсагнах, найрсагаар хамтран ажиллах бодлого явуулна гэсэн санаа юм². Бас нэг гол чухал зүйл бол эвсэлд үл нэгдэх бодлого явуулах тухай юм. Энэ нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд бидний хувьд тэр л утгаар нь авч үзэхийн сацуу хоёр хөршийнхөө эсрэг үйл ажиллагаанд орж нөгөө хөршийнхөө эсрэг эвсэхгүй байх, эвсэл бусад улс гүрээнтэй холбоотны харилцаанд орж, хоёр хөршийнхөө эсрэг үйл ажиллагаа явуулахгүй байхыг юуны өмнө ойлгож байна.

Монгол улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр, дипломатын аргаар хангах; эдийн засаг, шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх явдал гадаад бодлогын тэргүүлэх чиглэл байна хэмжээн заасан нь гадаад бодлогын үндсэн суурь нь Монгол улсын аюулгүй байдал юм гэдгийг тодорхойлж өгчээ.

Өнөөдөр улам бүр даяаршиж буй дэлхий олон улсын харилцаанд хэрхэн оролцох цаашлаад өөрийн эдийн засгийг хэрхэн яаж хамгаалах, эрчимтэй хөгжүүлэх, шинжлэх ухаан технологийн ололтыг улс орондоо ашигтай түргэн шуурхай нэвтрүүлэх болон бусад улс орны соёл уламжлалыг суралцах, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах зэрэг нь улам идэвхитэй гадаад бодлогыг хүлээсээр байна.

Үзэл баримтлалд заасан олон тулгуурт гадаад бодлогын хувьд: тус үзэл баримтлалд манай гадаад бодлогын зургаан тэргүүлэх чиглэлийг зааж үндэсний эрх ашгаа дээдлэн бүх улс олон улсын байгууллагатай үзэл суртал, нийгэм, эдийн засгийн байгууламж зэргийг үл харгалзан хамтын ажиллагааг хөгжүүлэх нөгөөтэйгүүр үзэл баримтлалд улс төр, эдийн засгийн гадаад бодлогын чиглэлээр зогсохгүй шинжлэх ухаан, технологи болон соёл, хүмүүнлэгийн салбар дахь бодлогын агуулгыг тодруулан багтаасан мөн Монгол Улс бол дэлхийн хамтын нийгэмлэгийн хариуцлагатай нэг гишүүн дийлэнх олонхийн үнэт зүйлсийг хуваалцдаг бөгөөд хүний нийгмийн урагшлан давших хандлагыг дагасан орон гэдгийг үзэл баримтлалд онцлон дурдсан. Энэ нь Монгол орон олон түнш, олон "найз"-тайг давхар харуулах баримт³ буюу.

Тус үзэл баримтлалд заасан "нээлттэй", "олон тулгуурт", "идэвхитэй" гадаад бодлогыг Монгол Улс эрчимтэй явуулж тодорхой хэмжээний амжилтанд хүрч байна. Тухайлбал:

Сүүлийн 3 жилийн хугацаанд хоёр талын нийт 74 гэрээ, хэлэлцээр байгуулж, олон улсын 29 олон талт конвенцид нэгдсэн нь манай улсаас олон улсын хэмжээнд явуулж байгаа гадаад харилцааг өргөжүүлж, хамтын ажиллагааны эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд ач холбогдолтой боллоо.

Манай улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын түвшинд баталгаажуулах зорилго тавьж ажилласны дүнд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн цөмийн зэвсэг бүхий таван гүрний зүгээс аюулгүйн баталгаа олгож, хамтарсан мэдэгдэл хийсэн нь чухал ач холбогдолтой юм. Манай улсын цөмийн

¹ Мөн тэнд 3-р бүлэг 27-р зүйлийн 1

² М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс УБ.1999 4 дэх тал

³ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй УБ 2000. 54 дэх тал

зэвсэггүй статус нь бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байгаа билээ.

Гадаад бодлогын үзэл баримтлалыг, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай харьцуулан авч үзвэл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "эвсэлд үл нэгдэх гадаад бодлого явуулна" гэж заасан байдаг бол Гадаад бодлогын үзэл баримтлалд¹ зааснаар "цэргийн эвсэлд үл нэгдэх" гэсэн байдлаар эвсэлд үл нэгдэх асуудлыг хязгаартайгаар ойлгохоор заасан байна. Энэхүү зарчмын ялгаатай асуудлыг хэрхэн ойлгох вэ? гэдэг асуудал гарч ирж байна. Нөгөө нэг асуудал бол Монгол улс 1992 онд өөрийгөө цөмийн зэвсэггүй статустай хэмээн зарласан бөгөөд НҮБ-ийн зүгээс дэмжсэн тогтоол батласан, тус байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн байнгын таван гишүүн орнууд дэмжсэн мэдэгдлийг хийсэн, мөн цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийг дотооддоо батлан гаргасан өнөө цагт "цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх чиг шугам баримтлана"² гэсэн томъёоллыг үзэл баримтлалд хэрэглэхээс илүүтэйгээр шууд утгаар нь "хориглоно" гэсэн байдлаар тодорхойлсон нь дээрх байх талтай. Мөн гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол улс гадаад бодлогоо хэрэгжүүлэхдээ дараахь чиглэлийг баримтлан³ гээд 6 чиглэлийг дугаарлан оруулсан байна. Энэ нь Монгол улс гадаад бодлогоо 6 түвшингээр явуулах, өөрөөр хэлбэл улс бүртэй өөр өөр байдлаар /ялгавартай/ харилцана гэсэн ойлголтыг төрүүлж болох талтай.

Өнөөдөр Монгол Улсад мөрдөгдөж байгаа бүх хуулиудад үндэсний аюулгүй байдлын асуудал ямаг нэг байдлаар тусгагдсан байдаг. Гэхдээ үндэсний аюулгүй байдлын асуудлыг гол агуулагаа болгосон олон хуулиудыг нэрлэж болно.

Тэдгээрээс Үндэсний аюулгүй байдлын тухай /2001/, Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулиуд /2000/ нь Монгол Улсын үндэсний аюулгүй оршин байх харилцааг зохицуулах зорилготой батлагдсан гол хуулиуд юм.

- 2) Үндэсний аюулгүй байдлын тухай хууль нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг удирдан явуулагч, оролцогч субъектүүдийн үйл ажиллагааг тогтолцооны түвшинд уялдуулан зохицуулах эрх зүйн үндсийг тодорхой болгохгүйгээр үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, түүний залгамж, нэгдмэл чанарыг хангах нь бэрхшээлтэй байгаа зэрэг шалтгаанаас үүдэн хуулийг шинэчлэн батлах шаардлага урган гарсан. Өөрөөр хэлбэл, Үндэсний аюулгүй байдлыг хангахад оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах эрх зүйн үндсийг хуульчлан тодорхойлохыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл явцаас урган гарсан.

Ер нь бол Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хуулинд Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах гэсэн ойлголтыг гаргаж өгсөн явдал нь чухал ач холбогдолтой болсон юм.

Үндэсний аюулгүй байдлын хуулийн зорилт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчим, Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг уялдуулаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор батлагдсан.

Тус хуулинд "Үндэсний аюулгүй байдал" гэж Монгол Улсын язгуур ашиг сонирхолыг хангах гадаад, дотосд таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ⁴ гэж заасан. Тэрхүү "Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл

¹ Гадаад бодлогын үзэл баримтлал 3 зүйл

² Өрнө Дорно сэтгүүл. 1996 №1 7 дахь тал

³ Олон улсын харилцаа сэтгүүл. 1994 он №2 27 дахь тал

⁴ Өрнө Дорно сэтгүүл. 1996 №1 8 дахь тал

ажиллагаа” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгааг бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ гэж заасан байдаг¹ ба үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлж буй тухайн албан тушаалтан үйл ажиллагаандаа улс үндэснийхээ язгуур ашиг сонирхолыг эрхэмлэх хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх, нэгдмэл харилцан уялдуулан зохицуулагдсан байх, шуурхай, тасралтгүй байх, бодит мэдээлэлд үндэслэх, төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэх, нээлттэй байх зарчмуудыг үйл ажиллагаандаа баримтлах ёстой ба ингэснээр үндэсний аюулгүй байдал хангагдах үндэс бүрдэнэ² гэж үзсэн.

Дээрхи хуулинд үндэсний аюулгүй байдлыг хангахад Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар бүрэн эрхтэйгээр оролцохыг тус тус заасан.

Мөн тус хуулинд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний язгуур ашиг сонирхолд харш олон улсын гэрээ хэлэлцээр байгуулахыг хориглохоор заасан. Тус хуулийн хамгийн гол ололтуудын нэгэнд нь Үндэсний аюулгүй байдалыг хангахад байгууллага, иргэдийн оролцоог нарийвлан зааж өгсөн оршин гэж бодож байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулинд үндэсний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд ямар эрх, үүрэгтэй байх вэ гэдгийг дээр дурьдсан ёсоор зааж өгчээ.

Эцэст нь тэмдэглэхэд тус хуулинд үндэсний аюулгүй байдлан дотоод харилцаанг илүү тусгаад гадаад харилцаандаа хэрхэн анхаарах, ямар бодлого чиглэл барьж өөрийн орныхоо аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлуудаас мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасан гадаад харилцаандаа баримтлах зарчмуудыг хангалттай тусгаж чадаагүй нь гадаад харилцаандаа нэгдсэн бодлого чиглэл баримтлаж оролцох боломжийг сааруулж байна. Энэ байдал нь цаашлаад Монгол Улс гадаад харилцаагаа явуулахдаа хуулиа зөрчсөн, зөрчөөгүй гэсэн маргаан гарах түүгээр зогсохгүй гарсан маргааныг эцэслэн шийдвэрлэх бололцоог хааж байна гэж бодож байна.

Монгол улс 1992 онд өөрийгөө цөмийн зэвсэггүй статустай улс хэмээн зарласан. Ийнхүү зарласныг олон улсын хамтын нийгэмлэг болон, их гүрнүүд сайшаан хүлээж авсан. Өөрөөр хэлбэл Монгол улсын энэхүү статусыг юун түрүүнд цөмийн зэвсэгтэй улс гүрнүүд дэмжиж байгаага мэдэгдсэн. Мөн 1998 онд Өмнөд Африкийн Дурбан хотод болсон Эвсэлд Үл Нэгдэх Хөдөлгөөний XII дээд хэмжээний уулзалтын төгсгөлийн баримт бичигт цөмийн зэвсэггүй нэг улсын статусаа эрх зүйн үндэстэй болгох талаар Монгол улсын баримтлаж байгаа бодлогыг талархан дэмжсэн. Цаашилбал НҮБ-ын 54 дүгээр чуулганд Монголын төлөөлөгчдөөс санаачлан оруулсан “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолыг гишүүд консенсусаар баталсан. Тогтоолын 1 дүгээр зүйлд “Монгол Улс цөмийн зэвсэггүй байх статусаа тунхаглан зарласныг талархан хүлээн авав”³ гэжээ. Монгол улсын энэхүү алхам нь нэг улс цөмийн зэвсэггүй бүс нутаг байж болохыг баталж байгаагаараа олон улсын харилцааны практикт шинэлэг зүйл болсон юм.

Ийнхүү цөмийн зэвсэггүй статусаа заралсан явдал нь өөрөө дотооддоо “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” хуулийг батлан гарах үндэслэлийг тавьж өгсөн. Нэгэнт зарласан тэрхүү статустаа улс орон даяар мэдэж, энэ асуудлаарх

¹ Гадаад бодлогын үзэл баримтлалын 9-р зүйл

² Мөн тэнд 9-р зүйл

³ Мөн тэнд 12-р зүйлийн 1-6

эрх зүйн зохицуулалтыг үндэснийхээ түвшинд гаргаж ирэх асуудал чухлаар тавигдах болсноор энэхүү хуулийг батлан гаргах шаардлага үүсэн бий болсон.

Энэ хуулийн зорилт нь Монгол улсын аюулгүй байдлыг хангахад чухал хүчин зүйл болох Монгол улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь, түүний дотор агаар мандал, газар, ус, газрын хэвлийг цөмийн зэвсгээс ангид байлгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Цөмийн зэвсэг гэдэг нь цөмийн хянагдашгүй эрчим хүч гаргаж дайны зориулалтаар ашиглаж болох цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжийг ойлгодог бол "Цөмийн зэвсэггүй статус" гэж цөмийн зэвсгээс ангид байх эрх зүйн байдлыг ойлгоно.

Нэг улс бие дааж цөмийн зэвсэггүй газар нутаг болсон, түүнийгээ олон улсын хэмжээнд баталгаажуулсан явдал одоогоор байхгүй. Шинэ Зеланд 1985 онд Цөмийн зэвсгээс ангид байх, зэвсэг хураах, зэвсэглэлд хяналт тавих тухай хууль гаргасан боловч тэр нь бусад улсуудын нөлөөний улмаас амжилт гаргаагүй. Ер нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлэхэд чиглэсэн онцгой үйл явдал юм.

Монгол улсын цөмийн зэвсгээс ангид байх тухай эрх зүйн статусыг төрийн бодлогын хэмжээнд бататган цаашид нарийвчлан тодорхойлж мөрдөх нь итгэлцлийг улам бэхжүүлэх, Монгол улсын аюулгүй байдлын гадаад таатай орчинг бэхжүүлэх, тус улсын аюулгүй байдлыг бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдалтай холбоход ач холбогдолтой юм.

Монгол улсын цөмийн зэвсэггүй статус нь олон улсын хамтын нийгэмлэгт гарч буй шинэ хандлага бөгөөд цөмийн зэвсгийг дэлгэрүүлэхгүй байх өргөн цар хүрээтэй дэлхий хамтын ажиллагаанд Монгол улсын оруулж буй томоохон хувь нэмэр юм.

(ii) Дүгнэлт:

Өнөөдөр та бидний өмнө тавигдаж байгаа хамгийн тулгамдсан асуудал бол даяаршлийн энэхүү орон зайд үндэснийхээ гадаад аюулгүй байдлыг хэрхэн хангах, хамгаалах вэ? бусад улсуудын зүгээс үзүүлж болох сөрөг нөлөөллийг хэрхэн саармагжуулах, арилгах вэ? гэдэг асуудал болоод байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын аюулгүй оршин байх үндсийн нэг гадаад бодлого, аюулгүй байдлын эрх зүйн орчинг судлах цаашлаад түүнийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан байнга шинэчлэж байхыг олон улсын харилцаанд өндөөдөр өрнөж байгаа үйл явц биднээс шаардаж байна. Монгол Улсын аюулгүй байдлын асуудлыг "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль" баримт бичгүүд, харин олон улсын харилцаанд хэрхэн аюулгүй орших, байх, өөрийгөө хамгаалж авч үлдэх эрх зүйн үндсийг Гадаад бодлогын үзэл баримтлал /тунхлалын шинж, чанартай заалтуудыг тусгасан/ баримт бичгээр тус тус зохицуулж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалуудад тусгагдсан гадаад харилцаанд баримтлах зарчмуудын хувьд хуучин цөөн тооны улс оронтой харилцаж хөндлөнгийн улсаас тодорхой хэмжээний хяналтан дор гадаад харилцаагаа явуулж байсан үеэс бие даасан, нээлттэй ардчилсан нийгэмд шилжих болсон нөхцөл байдалд тохируулсан олон чухал шинэлэг зарчмын заалтуудыг тусгасан байна.

Тухайлбал:

-Нээлттэй гадаад бодлого явуулах гэсэн заалт нь ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засагын харилцаанд шилжин орж байгаа цаг үеийн нөхцөл байдлын онцлогыг харгалзсан, (Дэлхийг хамарсан даяарших үйл явц, харилцан хамаарал ихсэн гадаад дотоод бодлого улам бүр шүтэлцээтэй болж, дотоод бодлогод гадаад буй олон улсын харилцааны хүчин зүйлийн үүднээс улбаалан дотоодод үүссэн бэрхшээлийг шийдвэрлэхэд гадаад бодлогын үүрэг ач холбогдлыг үнэн зөв үнэлсэн.)

-Үндэсний ашиг сонирхлоо дээдлэх, олон түнштэй байх, тууштай зарчимч байх бодлого явуулах Үндэсний язгуур ашиг сонирхолд аюул занал учраагүй нөхцөлд Монгол Улс эвсэлд үл нэгдэх бодлого явуулах гэсэн заалтуудаар их гүрнүүдийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх аливаа улсаас хараат бус байдалд орохоос сэргийлсэн, (Энэхүү зарчмыг барьж ажилласнаар АНУ, Япон, ХБНГУ, БНСУ, Европын холбоо зэрэг улс орнуултай харилцаагаа өргөжүүлсэн.)

-Монгол Улс хөрш хоёр оронтойгоо харилцах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгч, тэнцвэртэй харилцах зарчим баримтлах, хоёр орны маргаанд эс оролцож төвийг сахих бодлого баримтлах гэсэн заалтаар аюулгүй оршин байх явдал нь хоёр хөрш оронтой салшгүй холбоотой тэдгээрийн ашиг сонирхолын тэнцвэрийг хангах явдал чухал болохыг, (Хоёр хөрштэйгээ тэгш хиарлцах зарчим баримтласнаар БНХАУ гэх чухал хөрштэй харилцаагаа бүрэн хэвийн болгож чадсан)

-Үндэснийхээ аюулгүй байдлын Олон улсын баталгааг дангаар, 2 болон олон талын арга хэмжээг хослуулах замаар буй болгон цэрэг улс төрийн баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх оролцох замаар хангана¹ гэсэн заалтаар өөрийн аюулгүй байдлаа дангаар хангах боломжгүй учраас бусад улс, олон улсын байгууллагын хамтын хүчээр хангах, аюулгүй байдлыг хангахад идэвхитэй дипломат ажиллагаа чухал болохыг тус тус тусгаж өгснөөрөө аюулгүй байдлыг хангах боломж, нөхцлийг бидэнд олгосон чухал ач холбогдол бүхий заалтуудыг тусгасан байна.

Гэхдээ дээрх баримт бичгүүдэд логик уялдаа муутай, цаг үеийн шаардлагаас хоцорсон эргэж харж тодотгол хийх шаардлагатай мөн хэрхэн яаж хэрэгжүүлэх арга, механизм нь тодорхой бус зарим зүйл, заалтууд байна. Тухайлбал:

1. Монгол Улс өөрийн аюулгүй байдлын Олон улсын баталгааг дангаар, хоёр болон олон талын арга хэмжээг хослуулах замаар буй болгон. Цэрэг улс төрийн баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх оролцох замаар хангана² гэж заасан. Энэхүү заалтыг Монгол Улс идэвхитэй гадаад бодлого явуулах бөгөөд цэрэг улс төрийн аюулгүй байдлын баталгааг улс орнуудтай эсвэл, холбоо бүр цаашлаад олон улсын байгууллагад нэгдэх замаар хангана гэж ойлгож байна. Энэ нь Монгол Улсын язгуур ашиг сонирхолд аюул занал учраагүй тохиолдолд эвсэлд үл нэгдэх бодлого явуулна гэсэн заалттай зөрчилдөж байна. Энэ нь аюулгүй байдлаа хангах тогтолцоо бий болоод Монгол Улс түүнд нэгдэж аюулгүй байдлаа хангадаг юм гэхэд нөгөө аюул учруулж болохуйц, учруулж байгаа улс, хүчинтэй зөрчилдөх байдал бий болсон тохиолдолд хэрхэн хандах асуудал тусгагдаагүй байна. Энэ нь олон улсын зөрчилд жижиг улс илүүтэйгээр хохирдог туршлагыг эргэн санахад хүргэж болох талтай,

2. Гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улсын гадаад бодлогыг тодорхойлохдоо олон улсын харилцааны цаашдын хандлага, хөгжил, дэлхий болон бүс нутгийн улс төрийн байдалтай нягт уялдуулж тэргүүлэх чиглэл, зорилтыг нь тогтоохдоо уян хатан хандаж байна³ гэж заасан энэ нь тухай цаг үеийн байдлаас шалтгаалж тэргүүлэх чиглэл, зорилт өөрчлөгдөж болохыг тодорхойлож өгсөн боловч. Харин тэрхүү өөрчлөлтийг хэрхэн яаж, ямар хөшүүрэгээр, хэн санал гаргаж, хэрхэн хэлэлцэж өөрчлөлт оруулах нь тодорхой биш байна. Энэ асуудлыг тодорхой болгосон нэмэлтийг нэн яаралтай хийх нь зүйтэй. Харин дээрх асуудлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл

¹ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй УБ.1999. 81 дэхь тал

² Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 27 зүйлийн 2-ын 3, Гадаад бодлогын үзэл баримтлал 3 зүйл

³ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 27 зүйл 2-ын 1, Гадаад бодлогын үзэл баримтлал нийтлэг 3 зүйл

баримтлалд заахдаа тус үзэл баримтлалд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн санал болгосноор Улсын Их Хурал зохих нэмэлт, өөрчлөлт оруулж байна¹ гэж заасан заалтаас үлгэр авч болно.

Дээрхи нөхцөл байдалд дүгнэлт хийж Монгол Улсаад гадаад харилцааны олон улсын үйл явцад баримтлаж байгаа байр суурь зэргийг харгалзан холбогдох хууль, баримт бичгүүдэд дараах, өөрчлөлтийг хийх шаардлагатай байна гэж үзэж байна. Үүнд:

-Монгол Улсын гадаад аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдол бүхий дээрхи үзэл баримтлал, хуулинд гадаад харилцаандаа баримтлахаар заасан зарчмуудыг эргэн харж цаг үеийн байдалтай холбогдох зарим өөрчлөлт, тодотголыг хийх /тэр дундаа “эвсэлд үл нэгдэх” гэсэн асуудалд тодотгол хийх нь зүйтэй юм/.

-Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиуд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад аюулгүй байдлын баталгааг хангах үйл ажиллагаанг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхэд үнлэлт өгөх, цаашлаад гадаад бодлого, олон улсын харилцаа гадаад аюулгүй байдлын асуудлыг тусган гадаад бодлогын үзэл баримтлалтайгаа уялдсан гадаад харилцаанд оролцох ялангуяа, төрийн дээд шатны байгууллагуудын ажил үүргийн уялдаа холбоо, шийдвэр гаргах механизм ба харилцан хяналт тавих, хүлээх хариуцлага, эрх үүрэг зэргийг тусгасан хуулийг батлан гаргаж үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай байна гэж үзэж байна. Энэхүү хуулийг баталснаар Монгол Улсаад гадаад харилцаандаа баримтлах бодлого нь нэгдмэл, залгаж чанартай болно гэж ойлгож байна.

Эцэст нь тэмдэглэхэд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улс хөрш хоёр оронтойгоо харилцах асуудалд тэргүүн зэргийн ач холбогдол өгнө гэж заасан байдаг. Гэвч Монгол Улс олон улсын чанартай нэлээдгүй асуудалд хөрш улсуудаасаа урьдаж мэдэгдэл хийгээд зогсохгүй сөрөг байр, суурь баримталсан. Монгол Улс цаашдаа олон улсын харилцаанд оролцохдоо аливаа асуудлаар хоёр хөрш улсынхаа байр суурийг нэн тэргүүнд харгалзаж байх нь зүйтэй гэж бодож байна. Өнөөдөр хөрш улсууд маань дотоодын асуудалдаа анхаарал тавиад гадаад асуудалд төдийлөн идэвхитэй байр сууринаас оролцохгүй байгаа байдал ажиглагдаж байна. Хоёр хөрш улсууд маань дотоод асуудлаа шийдвэрлээд олон улсын харилцаанд идэвхитэй байр суурь баримтлаж эхэлсэн тохиолдолд асуудал ямар байр сууринаас хандах вэ? гэдгийг бодолцож байх нь зүйтэй, Гэхдээ энэ нь олон улсын харилцаанд явуулах үйл ажиллагаагаа хөрш улсуудаараа заалгах ёстой гэсэн үг биш гэдгийг тэмдэглэхийг хүсэж байна.

Ном зүй

Ном сурах бичиг:

1. Г.Батаа, С.Галсанжамц. Монгол Улсын аюулгүй байдал /Орос Монголын судлаачдын үзэл бодол/ УБ.1999
2. Ж.Бор. Монголын тусгаар тогтнолын гэрэл сүүдэр УБ.1996
3. О.Билэгбат. Төв азийн аюулгүй байдал ба Монгол улс УБ. 2003
4. Д.Баярхүү. Евразийн геополитик, олон улсын харилцаа /одоо ба ирээдүй УБ.2002

¹ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 27 зүйл 2-ын 2, Гадаад бодлогын үзэл баримтлал 12-р зүйлийн 1

5. *С.Дашицэвэл. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гуравдах түнш орнууд УБ.2002*
6. *Д.Далайжаргал. Олон улсын терроризм ба Монгол улсын үндэсний аюулгүй байдал УБ.1999*
7. *М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй УБ.1999*
8. *М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Дипломат ажиллагаа, дипломат албаны үндэс*
9. *Дорно дахин судлалын хүрээлэн 1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол Улс-Их гүрнүүдийн харилцаа*
10. *Д.Лүндээжанцан. Аюулгүй байдал, хөгжил, төр эрх зүй УБ 2002*
11. *Д.Лүндээжанцан. Үндсэн хуулийн эрх зүй УБ 2000*
12. *Н.Лүндэндорж. Төрийн онол УБ.1997*
13. *Монгол Улсын төрийн үзэл баримтлал, бодлого чиглэл УБ.2002*
14. *Найдансүрэн, Д.Содномгомбо. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал түүнийг хангах зарим асуудал УБ.2000*
15. *Ц.Сарантуяа. Төрийн ерөнхий онол. УБ.1999*
16. *Т.Сэнгэдорж. Хуульчийн мэргэжил УБ.2000*
17. *Т.Сэнгэдорж. Монгол Улсын төр, эрх зүйн үндэс. УБ.2000.*
18. *Т.Сэнгэдорж.Хуулийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. УБ.2001*
19. *Я.Чимгээ. Ази-Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо: Монгол улсын хувь нэмэр УБ.2003*
20. *Д.Чулуунжав. Монголын төрийн тогтолцоо, түүний хууль эрхийн үндэсүүд дэхь дутагдал, согог, асуудлууд /1990-1999/. УБ.1999*
21. *Р.Болд, Б.Ганбаатар. Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал. УБ.2002.*

Section 1.03**Section 1.04 Олон улсын эрдэм шинжилгээний хурал симпозиум:**

1. "Глобальчлалын Эрин дэх Хүний Аюулгүй Байдал". /Олон Улсын бага хурал/ УБ.2000
2. "Глобальчлал, Монгол Улсын хөгжил". /Эрдэм шинжилгээний бага хурал/ УБ.2002
3. "Хүний эрх ба Үндэсний аюулгүй байдал". /Олон улсын симпозиум/ УБ. 1998

Section 1.05 Хууль, Үзэл баримтлал, баримт бичгүүд:

1. Үндсэн хууль /1992/
2. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /1994/
3. Гадаад бодлогын үзэл баримтлал /1994/
4. Монгол улсын төрийн цэргийн бодлогын үндэс/1998/
5. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль /2001/
6. Цөмийн зэвсэгээс ангид байх тухай хууль /2000/
7. Батлан хамгаалах цагаан ном /2001/
8. Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого /1996/
9. Гадаад бодлогын хөх ном /2000/

Интернет эх сурвалж:

1. www.Gate1.pmis.gov.mn /Ерөнхийлөгч/
2. www.Pmis.gov.mn/nsc/ /Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл/
3. www.Pmis.Gov.mn /Монгол Улсын Засгийн Газар/
4. www.Extrmin.mn /Гадаад Хэргийн Яам/
5. www.Monjustice.mn /Хууль Зүй Дотоод Хэргийн Яам/
6. www.Pmis.gov.mn/mdef/ /Батлан Хамгаалах Яам/

Сонин, сэтгүүл:

1. Зууны мэдээ сонин
2. Стратеги судлал сэтгүүл /1999 №2, 2001 №1-2/
3. Олон улсын харилцаа сэтгүүл /2001 №1, 2002 №1-2/
4. *Дорно Өрнө.сэтгүүл* /1996 № 2, 1999 №2-3,/